



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/15

Модот

Ажлын хэсэг томилох тухай
(Мал эмнэлгийн дүк машин, Мод услах универсал
автомашин авах)

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн, 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, 50 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа Мал эмнэлгийн дүк машин, Мод услах универсал авто машин худалдаж авах ажилд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:


Ажлын хэсгийн ахлагч П.Ганчимэг – Мал эмнэлгийн Улсын байцаагч

Нарийн бичгийн дарга Д.Оюунбаяр - ИТХурал, Соёл хариуцсан нягтлан бодогч

Гишүүд П.Баярсайхан – Ойн ангийн дарга

2.Дээрх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, байгуулсан гэрээний дагуу гэрээг дүгнэх, хүлээн авах акт үйлдэх, гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгчээр гаргуулж авахыг ажлын хэсгийн ахлагч (П.Ганчимэг) –д үүрэг болгосугай.

ДАРГА



Ү.ИЧИНХОРЛОО